



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВ**

Нам Ян Жугийн гудамж 32/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13335
Утас: 45 39 94, Факс: (976-11) 45 86 99,
Цахим шуудан: info@nccd.gov.mn,
Цахим хуудас: www.nccd.gov.mn

2025.02.24 № 3-3/262
танай _____-ны № _____-т

**ЦАХИМ БҮРТГЭЛ МЭДЭЭЛЛИЙН
СИСТЕМ ХӨГЖҮҮЛЭГЧ
БАЙГУУЛЛАГУУДАД**

Үнийн санал авах тухай

Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд орчин үеийн программ хангамж, дэвшилд нийцүүлэн тохиолдолд суурилсан (case based) бүртгэл мэдээллийг бодит цаг хугацаанд (real time) бүртгэн мэдээлэх боломжтой цахим системийн хөгжүүлэлт 2022 онд хийгдэж, 2023 оноос эхлэн 34 эрүүл мэндийн байгууллага өдөр тутам ашиглан, үндэсний хэмжээний мэдээ, мэдээллийн санг баяжуулан ажиллаж байна.

Тус систем нь PHP, React Native програмчлалын хэл дээр бичигдсэн бөгөөд 400,000 гаруй өвчтөний мэдээлэл, 840,000 гаруй үйлдлийн бүртгэлийг хадгалсан томоохон цахим бүртгэл мэдээллийн систем юм.

Цаашид сүрьеэгийн цахим систем болон мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, сервер болон системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, бусад эрүүл мэндийн цахим системүүдийг холбох, өдөр тутам гарсан алдаа, хэрэглэгчийн саналыг үндэслэн засвар үйлчилгээг тогтмол хийх ажлуудыг гүйцэтгүүлэх гэж байгаа тул "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дах заалтын дагуу 2025 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн дотор үнийн саналыг ирүүлнэ үү. Саналыг байгууллагын албан тоотоор баталгаажуулж холбогдох материалын бүрдлийг ханган tender@nccd.gov.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Шалгуур үзүүлэлтийг хавсралтаар орууллаа.

Хавсралт ./. хуудас

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.АНХБАЯР

My document/2025 alban toot

1325030201

Халдварт Өвчин Судлалын Үндэсний
Төвийн 2025 оны 3-р сарын 26-д дугаартай
албан бичгийн хавсралт



Сүрьеэгийн цахим бүртгэл мэдээллийн системийн сайжруулалт, завсар үйлчилгээг
үзүүлэх ажлын мэргэжлийн байгууллагыг сонгох шалгуур үзүүлэлт

1. Ерөнхий шаардлага

- Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
- Компанийн танилцуулга (гэрээт ажил дээр ажиллах хүний нөөцийн бүтэц, чадавхи)
- Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлага (товч тайлбар)
- Эмнэлгийн программ хангамж дээр ажиллаж байсан туршлага (Сүрьеэ өвчний талаар мэдлэг мэдээлэлтэй)

2. Технологийн шаардлага

- Программчлалын хэл: PHP
- Back-End: Laravel
- Front-End: VueJS, Bootstrap
- Database: MySQL
- Мобайл аппликейшн: React Native (App Store, Google Play-д байршуулж туршлагатай байх)
- Системийн эх кодыг тайлж унших чадамжтай

3. Гүйцэтгэх ажил

- Өмнөх онуудын цахим системийн хөгжүүлэлтийн саналын дагуу засвар үйлчилгээг үргэлжлүүлэн гүйцэтгэх
- Мобайл аппликейшн сайжруулж, App Store, Google Play-д байршуулж холбох
- Төрөлжсөн мэдээний сан болон халдварт өвчний мэдээллийн сантай интеграци хийх
- Өдөр тутмын алдаа засвар, засвар үйлчилгээг тогтмол хийх
- Мэдээллийн аюулгүй байдал, серверийн найдвартай ажиллагааг хангах
- Дараах материалыг хүлээлгэн өгөх:
 - Программ хангамжийн эх код
 - Өгөгдлийн сангийн database файл
 - Видео заавар, тайлбар
 - Системийн админы тохиргооны гарын авлага
- Хөгжүүлсэн программ хангамжийн эх код болон оюуны өмч нь ХӨСҮТ-д хамаарна.
- Нийт төсөв: 18,000,000